



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/189

Улаанбаатар хот

БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, хянах
арга хэмжээний төлөвлөгөө (2026-2029 он)
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.6 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, хянах арга хэмжээний төлөвлөгөө (2026-2029 он)-г нэгдүгээр, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан)-т, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв)-т, хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (С.Энхболд)-д тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүн, үр ашгийг тооцон тайлагнаж байхыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт, тайланг нэгтгэн жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвд ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсөв, хамтын ажиллагаатай улс, орон болон олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж, нэгдсэн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан)-т ирүүлж байхыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (С.Энхболд)-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Янжмаа)-т даалгасугай.

САЙД

Э.БАТШУГАР



141261033

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 05
сарын 28 өдрийн А/189 дүгээр
тушаалын нэгдүгээр хавсралт

БЗДХ, ХДХВ/ДОХ-ООС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ
АРГА ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨГӨӨ (2026-2029 он)

Нэг. Нийтлэг үндэслэл

Тогтвортой хөгжлийн хөтөлбөрт 2030 он гэхэд нийгмийн эрүүл мэндэд занал учруулж буй БЗДХ, ХДХВ ДОХ-ын тархалтыг зогсоохыг улс орон бүрд үүрэг болгосон. Монгол Улсын Засгийн газар 95-95-95 зорилт болон “2030 онд ДОХ-ыг зогсоох” зорилтыг хэрэгжүүлэхийн тулд эрсдэлт бүлгийн хүмүүсийн дундах шинэ тохиолдлыг бага түвшинд байлгах, урьдчилан сэргийлэх төрөлжсөн үйлчилгээг өргөжүүлэх, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний төрөлжсөн үйлчилгээг өргөжүүлэх замаар ХДХВ-ийн халдварын тохиолдлын илрүүлэлтийг нэмэгдүүлэх, ХДХВ-ийн эмчилгээ, тусламжийн төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх, бодлогын ээлтэй орчин бүрдүүлэх, эрүүл мэндийн бат бөх, тогтвортой тогтолцоо, ХДХВ-ийн халдвараас сэргийлэх хариу арга хэмжээг сайжруулах үүрэг хүлээсэн.

“ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратеги төлөвлөгөө”-г 2010-2015 онд хэрэгжүүлж, 2017 он хүртэл сунгасан¹. Энэ стратеги нь эрсдэлт бүлгийн хүн амын дундах ХДХВ-ийн халдварын тархалтыг 5.0%-иас доош тогтоон барьж эдгээр бүлгийн хүн амын дундах халдвар дамжихыг бууруулах замаар нийт хүн амын дунд халдвар тархахаас сэргийлэх зорилттой хэрэгжсэн Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд нийт хүн амын дунд ХДХВ-ийн халдварын тархалтыг бага түвшинд нь тогтоон барьж ХДХВ-ийн халдвар эхээс хүүхдэд болон цус, цусан бүтээгдэхүүн, эмнэлгийн дотоод халдвараар дамжсан тохиолдол бүртгэгдээгүй, ХДХВ-ийн халдварыг эрт үед нь оношилж, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, өртөлтийн өмнөх болон дараах сэргийлэлтийн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлснээр ретровирусийн эсрэг эмчилгээ (РВЭЭ)-ний хамрагдалт 87.3%-тай болж, ДОХ-ын шалтгаант нас баралт, халдварын тархалтыг бууруулж чадсан, бүх донорын цус, цусан бүтээгдэхүүнд ХДХВ, гепатитын В, С вирус, тэмбүү өвчнийг илрүүлэх шинжилгээг 100% хийж байгаа нь томоохон амжилт байв.

Монгол Улсын хэмжээнд 2024 оны байдлаар тэмбүү, заг хүйтэн, трихомониазын 12,111 тохиолдол бүртгэгдсэн нь тухайн жил бүртгэгдсэн нийт халдварт өвчний 32.6%-ийг эзэлж байна. Тэмбүүгийн тохиолдол 10.000 хүн амд 15.0 байна. Төрөлхийн тэмбүү анхаарал татсан асуудлын нэг хэвээр байж, 2024 онд төрөлхийн тэмбүүгийн нийт 13 тохиолдол бүртгэгдсэн нь 100.000 амьд төрөлтөд 22.5 тохиолдол байна.

¹ ДОХ-ын Үндэсний Хороо. ХДХВ, ДОХ, БЗДХ-ын Үндэсний Стратеги Төлөвлөгөө (УСТ) 2010-2015 (хожим 2017 он болгон сунгасан).

Нийт хүн амын дундах ХДХВ-ийн халдварын тархалтын түвшин 0.1%-иас бага, эрсдэлт бүлгийн хүн ам, ялангуяа эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд (ЭБЭ) болон трансжендер хүмүүс (ТЖХ)-ийн дунд төвлөрсөн тархалттай байна (ХДХВ-ийн халдварын тархалт 5.6-5.7%). 2022 оны байдлаар ЭБЭ-ийн дундах тархалтын хувь 5.6% ба ТЖЭ-ийн дундах тархалт 5.7% байна². Улаанбаатар хот болон 3 аймгийн биеэ үнэлэгчдийн дундах тэмбүүгийн тархалт 12%, трансжендерүүдийн дундах тэмбүүгийн тархалт 32.4% байна.

Халдварын тархалт нэмэгдэхэд хөдөлгөөнт хүн ам, биеэ үнэлэлт, зам болон уурхайн салбар, бэлгийн замын халдварын тархалт өндөр байх, ялангуяа тэмбүүгийн тархалт, архины хэрэглээ, хамаарлын түвшин өндөр, тэгш бус байдлын түвшин өндөр, ЭБЭ, эмэгтэй биеэ үнэлэгч (ЭБҮ), ТЖХ, ХДХВ-ийн халдвартай амьдарч байгаа хүмүүсийг ялгаварлан гадуурхах түвшин өндөр, ядуурал зэрэг нийгэм зан үйлийн хүчин зүйлс нөлөөлж байна.

Монгол Улсад бүртгэсэн ХДХВ-ийн халдварын тохиолдлын 99.7% нь бэлгийн замаар дамжсан байна². ХДХВ-ийн халдвар эрсдэлт бүлгийн хүн амын дунд төвлөрч тархсан бөгөөд 87.5% нь ЭБЭ (зан үйлийн хувьд тодорхой тооны бисекс болон гэрлэсэн хүмүүс) байна. 2024 онд шинээр бүртгэгдсэн 19 тохиолдлоос 18 тохиолдол нь ЭБЭ (9), трансжендер (1), бисекс эрэгтэй (9) байжээ². Тооцоолж буй ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн 60% нь ЭБЭ, 7% трансжендер, 16% эрсдэлт бүлгийн бус эрэгтэйчүүд, 14% нь эрсдэлт бүлгийн бус эмэгтэйчүүд, 1% нь эмэгтэй биеэ үнэлэгч, 2% нь ЭБҮ-гийн үйлчлүүлэгчид байна.

Засгийн газраас ХДХВ-ийн халдвараас сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлж амлалтаа хэрэгжүүлж байгаа ч эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, шинжилгээ, үйлчилгээ зэрэг олон үйл ажиллагааг Глобаль сангийн дэмжлэгтэйгээр санхүүжүүлсэн хэвээр байна. 2024 оны ДОХ-ын тархалтын загварчлал (ДТЗ)-аар 1998-2023 онд хэрэгжүүлсэн ХДХВ/ДОХ-оос сэргийлэх хариу арга хэмжээний үр дүнд нийт ХДХВ-ийн шинэ халдварын 18296 тохиолдол, ДОХ-оос үүдэлтэй нас баралтын 4503 тохиолдол гарахаас сэргийлж чадсан боловч, энэ хангалтгүй байна. Хэрэв 2026 оноос урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөжүүлэхгүй бол 2050 онд дараах нөхцөл байдалд хүрэх эрсдэлтэй:

- ХДХВ-ийн халдварын шинэ тохиолдол жилд: 704;
- ХДХВ, ДОХ-той нийт хүний тоо: 7428;
- ДОХ-оос үүдэлтэй нийт нас баралт: 341;
- РВЭЭ шаардлагатай хүн: 7433.

2023 онд хийсэн БЗДХ, ХДХВ/ ДОХ-ын үндэсний хариу арга хэмжээний нөхцөл байдлын SWOT дүн шинжилгээгээр БЗДХ, ХДХВ-ийн тандалтын бүртгэл мэдээлэлд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын оролцоо сул, аймаг, дүүргийн түвшинд диспансер бус зөвхөн кабинет ажилладаг, ХДХВ-ийн халдварын тохиолдлын бүртгэл мэдээлэл цаасан хэлбэрээр хийгдэж байгаа нь тайлан мэдээний чанарт эрсдэл

² NCCD presentation at the Consultation meeting of GAM report, 27 March 2023

учруулдаг, ХДХВ/ДОХ-ын цахим бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бүрдээгүй, БЗДХ оношлогдсон хүний хавьтлыг илрүүлэх, хавьтлын оношилгоо, эмчилгээ хангалттай хийгдэхгүй, ХДХВ-ийн халдвартай амьдарч буй хүмүүс, эрсдэлт бүлгийн хүн амд хэрэгцээтэй тусламж, үйлчилгээг цогц байдлаар үзүүлдэггүй, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд багтаагүй зэргээс тусламж, үйлчилгээний хүртээмж, мэргэшсэн хүний нөөц дутагдалтай хэвээр байна.

Хоёр. Мандатын шинжилгээ

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үр дүн, үр ашиг, ба тогтвортой байдлыг хангаж ажиллана.

2.1. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд: Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх талаар улсын хэмжээнд баримтлах төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, эдийн засаг, санхүү, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд салбар, салбар хооронд, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

2.2.Төсөв санхүүгийн хүрээнд: Үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг үйл ажиллагааны санхүүжилт болон олон улсын байгууллагын төслийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бөгөөд холбогдох тайлагналтыг Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллана.

Гурав. Арга хэмжээний зорилго, зорилт

3.1 Зорилго: БЗДХ, ХДХВ-ийн халдварын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар тархалтыг тогтоон барих

3.2 Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

3.2.1 БЗДХ, ХДХВ-ийн чиглэлээр хэрэгжиж буй хууль, эрх зүйн орчныг сайжруулж, боловсруулах;

3.2.2 Хүн амын дунд БЗДХ, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг зохион байгуулах, мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг өргөжүүлэх;

3.2.3 БЗДХ, ХДХВ/ДОХ-той хүмүүсийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

3.2.4 БЗДХ, ХДХВ/ДОХ-ын нотолгоонд суурилсан хяналт, тандалт, мэдээллийн системийг боловсронгуй болгох.

Дөрөв. Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчим

4.1 Арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

4.1.1 БЗДХ, ХДХВ/ДОХ-оос сэргийлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, иргэн бүрд сайн дурын үндсэн дээр, нууцлалыг хадгалан чанартай үйлчилгээ үзүүлэх;

4.1.2 Үйлчлүүлэгчийн нэр төрийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх;

4.1.3 Үйлчлүүлэгч төвтэй, оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг хангаж, нотолгоонд тулгуурлах.

Тав. Хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа

5.1 Арга хэмжээг 2026-2029 онд хэрэгжүүлнэ.

Зургаа. Арга хэмжээний санхүүжилт

6.1 Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

6.1.1 улсын болон орон нутгийн төсөв;

6.1.2 олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

6.1.3 гадаадын зээл, буцалтгүй тусламж;

6.1.4 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;

6.1.5 хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Долоо. Арга хэмжээний үр дүн

7.1 Арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

7.1.1 БЗДХ, ХДХВ-ийн чиглэлээр хэрэгжиж буй хууль, эрх зүйн орчныг сайжруулна.

7.1.2 Хүн амын дунд БЗДХ, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг зохион байгуулах, мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг өргөжүүлнэ.

7.1.3 БЗДХ, ХДХВ/ДОХ-той хүмүүсийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

7.1.4 БЗДХ, ХДХВ/ДОХ-ын нотолгоонд суурилсан хяналт, тандалт, мэдээллийн систем боловсронгуй болно.

БЗДХ, ХДХВ, ДОХ-ОС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, 2026-2029 ОН

№	Арга хэмжээ	Эх үүсвэр	Нийт төсөв (сая төгрөг)	Суурь түвшин	2026 он				2027 он				2028 он				Хэрэгжүүлэх байгууллага	
					Хүрэх түвшин		Төсөв (сая төгрөг)	Хүрэх түвшин		Төсөв (сая төгрөг)	Хүрэх түвшин		Төсөв (сая төгрөг)	Хүрэх түвшин		Төсөв (сая төгрөг)	Үндсэн	Хамтрагч
					Хүрэх түвшин	Төсөв (сая төгрөг)		Хүрэх түвшин	Төсөв (сая төгрөг)		Хүрэх түвшин	Төсөв (сая төгрөг)		Хүрэх түвшин	Төсөв (сая төгрөг)			
Зорилго: БЗДХ, ХДХВ-ийн халдварын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар тархалтыг тогтоон барих																		
Зорилт 1: БЗДХ, ХДХВ-ийн чиглэлээр хэрэгжиж буй хууль, эрх зүйн орчинг сайжруулна																		
1.1	БЗДХ, ХДХВ/ДОХ-ын тусламж үйлчилгээний зааврыг нотолгоонд суурилан боловсруулах, шинэчлэх	Глобал сан	21,0	Батлагдсан удирдамжийн тоо 1	-	-	-	-	1	21,0	-	-	-	ЭМЯ, ХӨСҮТ	Холбогдох төрийн болон ТББ-ууд			
1.2	БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж үйлчилгээний бүтэц, зохин байгуулалтыг үнэлэх	Глобал сан	56,0	Үнэлгээ хийж байгаагүй	Үнэлгээ хийгдсэн байна	56,0	-	-	-	-	-	-	-	ЭМЯ, ХӨСҮТ	Холбогдох төрийн болон ТББ-ууд			
1.3	Улсын хэмжээнд хүний цөөнцийг бэлтгэх, чадавжуулах замаар тусламж үйлчилгээний хүртээмжийн индексийг нэмэгдүүлэх	Глобал сан	105,0	Хүртээмжийн индекс 54.8	Хүртээмжийн индекс 70	35,0	Хүртээмжийн индекс 80	35,0	Хүртээмжийн индекс 90	35,0	Хүртээмжийн индекс 90	-	-	ЭМЯ, ХӨСҮТ	Холбогдох төрийн болон ТББ-ууд			
1.4	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад БЗДХ-ын илрүүлэг, хяналт, эмчилгээг нэвтрүүлж, тохиолдолд суурилсан санхүүжилтийг үе шаттайгаар нэвтрүүлэх	-	-	-	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын чадамжийн үнэлгээ хийсэн байна	-	Чадавжуулах сургалтыг явуулсан байна	-	БЗДХ-ын стандарт илрүүлж нэвтрүүлж үр дүнтэй загварыг өргөжүүлж, ЭМД-ын багцад хамруулсан байна	-	БЗДХ-ын илрүүлэг, хяналт, эмчилгээг бүрэн нэвтрүүлсэн байна	-	-	ЭМДЕГ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, холбогдох ТББ			
1.5	Эрсдэлт бүлгийн хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж буй байгууллагын гүйцэтгэлд суурилсан үйл ажиллагааг улсын төсөвт оруулах нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах	Глобал сан	5,0	ЭМДҮЗ-ийн 04 тогтоолд суугаагүй	Нөлөөллийн үзлэлт зохион байгуулагдсан байна	5,0	-	-	-	-	-	-	-	ЭМЯ, ХӨСҮТ	Холбогдох төрийн болон ТББ-ууд			
1.6	Эрсдэлт бүлгийн хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж буй байгууллагын гүйцэтгэлд суурилсан үйл ажиллагааг улсын төсөвт оруулах	Глобал сан	70,0	-	-	-	Гүйцэтгэлд суурилсан үйл ажиллагааг улсын төсөвт оруулсан байна	10,0	Үйл ажиллагааг тогтворжуулсан байна	30,0	Үйл ажиллагааг тогтворжуулсан байна	-	-	ЭМЯ, ХӨСҮТ	Холбогдох төрийн болон ТББ-ууд			
1.7	ХДХВ-ийн халдвараас сэргийлэх өртөлтийн өмнөх сэргийлэлтийн тусламж, үйлчилгээний удирдамжийг боловсруулж батлуулах, удирдамжийн дагуу хүн амын онцлог хэрэгцээнд нь тохирсон сургалтыг тогтмол явуулах	Глобал сан	55,0	-	1 удирдамж боловсруулсан байна	22,0	Эрсдэлт бүлгийг хэнд үйлчилгээ үзүүлдэг ерөнхий мэргэжлийн болон БЗДХ, ХДХВ, ДОХ-ын эмч нарыг чадавжуулах сургалтыг улирал бүр тогтмол явуулсан байна	11,0	ХДХВ-ийн халдварын өртөлтийн өмнөх сэргийлэлтийн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, 1500 хүнийг чадавжуулсан байна.	11,0	ХДХВ-ийн халдварын өртөлтийн өмнөх сэргийлэлтийн мэдлэг олгох сургалтыг 1500 хүнд зохион байгуулсан байна.	-	-	ЭМЯ, ХӨСҮТ	Холбогдох төрийн болон ТББ-ууд			

1.8	ХДХВ-ийн халдвар илрүүлэх өөрийгөө шинжлэх болон олон нийтэд түшиглэсэн шинжилгээний удирдамж боловсруулах, удирдамжийн дагуу сургалт зохион байгуулах	Глобаль сан	55,0	-	1 удирдамж боловсруулсан байна	22,0	3 удаагийн сургалт зохион байгуулсан байна	11,0	3 удаагийн сургалт зохион байгуулсан байна	11,0	ЭМЯ, ХӨСҮТ	Холбогдох төрийн болон ТББ-ууд
1.9	ХДХВ/ ДОХ-ын хүн төвтэй чанартай, цогц тусламж үйлчилгээнд шаардлагатай ханган нийлүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулж, үе шаттайгаар улсын төсөвт суулах	Глобаль сан	12,800	жил бүр	Ретровирусын эсрэг эмийн ханган нийлүүлэлт, хуваарилалт хийгдсэн байна	2,747	Ретровирусын эсрэг эмийн ханган нийлүүлэлт, хуваарилалт хийх	3,049	Ретровирусын эсрэг эмийн ханган нийлүүлэлт, хуваарилалт хийх	3,351	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, дүүргийн ЭМГ
1.10	Аялал, зуулал, зочид буудлуудад "Бэлтгэвч"-ийг байршуулах, үйлчилгээний стандарт нэвтрүүлэх	-	-	-	Байгууллагуудын бэлэн байдал, хандлагын суурь судалгааг авч, үйлчилгээний стандартад тусуулсан байна	-	Зочид буудлуудад БЗДХ, бэлтгэвчийг зөв хэрэглэх ОР бүхий цахим зөвлөмжийг байршуулна	-	Аялал зуучлалын бааз, зочид буудлуудын өрөөнүүдэд бэлтгэвчийг байршуулж хэвшүүлнэ.	-	ССАЖЗЯ, АНЭДТ, ХӨСҮТ	Аймагийн ЭМГ
1.11	БЗДХ-ын оношилгоо, эмчилгээ, тусламж үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын бүртгэл мэдээллийн тогтолцоог сайжруулах	-	-	15	БЗДХ-ын оношилгоо, эмчилгээ, тусламж үйлчилгээ үзүүлэх эмчлэх тусгай зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын судалгааг гаргасан байна	-	БЗДХ-ийн бүртгэлжүүлэлтийн олон улсын стандарт схемийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ	-	олон улсын стандарт схем бүхий цахим бүртгэлийн системийг ХХЗМБ-д нэвтрүүлнэ	-	ЭМЯ, ЭМХТ, ХӨСҮТ, НЭМГ	Аймагийн ЭМГ
Хэсгийн дүн												
Зорилт 2: Хүн амын дунд БЗДХ, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх үзлэг, эрг илрүүлэх зохион байгуулах, мэдээлэл сургалт сурталчилгааны үйл ажиллагааг өргөжүүлэх			12,799			2,747	3,049	3,351	3,653			
2.1	Өсвөр үеийнхэнд бэлгийн болон нөхөн үржихүйн цогц мэдлэгийг "Хүүхэд өсвөр үеийн кабинет"-аар дамжуулан олгох	Глобаль сан	220,0	-	"Хүүхэд өсвөр үеийн кабинет"-ын үйлчилгээний машрутыг тодорхойлно.	40,0	Суралцдын мэдлэг, хандлагыг сургалтын агуулга, давтамжийг тодорхойлно	50,0	Баруун, зүүн бүсийн 20,УБ хотын 25 сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдад сургалт явуулна.	60,0	Хангайн бүс, төвийн бүсийн 20, УБ хотын 25 сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдад сургалт явуулна	Аймаг нийслэлийн Засаг даргын Тамгын газар
2.2	БЗДХ, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх мэдээллийг цахим хэлбэрээр зохион байгуулах	Глобаль сан	889,0	2025 онд 50,300 хүнд хүрсэн байна	60,000 хүнд хүрсэн байна	202,0	70,000 хүн	209,0	80,000 хүн	239,0	ЭМЯ, ХӨСҮТ	Холбогдох төрийн байгууллагууд
2.3	Улсын хэмжээнд 15-24 насны залуучуудын дунд урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгаа зохион байгуулах	Глобаль сан	80,0	2023 онд 15-24 насны эрэгтэйчүүдийн дундах цогц мэдлэг 20%, эмэгтэйчүүдийн дундах цогц мэдлэг 25%-иар нэмэгдсэн байна.	15-24 насны эрэгтэйчүүдийн дундах цогц мэдлэг 22%, эмэгтэйчүүдийн дундах цогц мэдлэг 27%-д хүргэнэ	20,0	15-24 насны эрэгтэйчүүдийн дундах цогц мэдлэг 24%, эмэгтэйчүүдийн дундах цогц мэдлэг 29%-д хүргэнэ.	20,0	15-24 насны эрэгтэйчүүдийн дундах цогц мэдлэг 26%, эмэгтэйчүүдийн дундах цогц мэдлэг 29%-д хүргэнэ.	20,0	ЭМЯ, ХӨСҮТ, НЭМГТ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, Холбогдох төрийн болон ТББ-ууд

2.4	Их, дээд сургууль, МСУТ-ийн ооутан, ЕБС-ийн суралцдаг дунд урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгаа зохион байгуулах	Глобаль сан	80.0	2023 онд 15-24 насны эрэгтэйчүүдийн дундах цогц мэдлэг 20%, эмэгтэйчүүдийн дундах цогц мэдлэг 25%	цогц мэдлэгийн түвшин 22%-д хүргэнэ	20.0	цогц мэдлэгийн түвшин 24%-д хүргэнэ	20.0	цогц мэдлэгийн түвшин 26%-д хүргэнэ	20.0	цогц мэдлэгийн түвшин 28%-д хүргэнэ	20.0	ЭМЯ, ХӨСҮТ, НЭМҮТ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, Холбогдох төрийн болон ТББ-ууд
2.5	Хүн амын тодорхой бүлгүүдийн ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх цогц мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэх	Глобаль сан	580.0	2022 он ЗӨУ: 18.2%, ЗӨС: 18.2%	ЗӨУ: 20.0%, ЗӨС: 20.0%	130.0	ЗӨУ: 25.0%, ЗӨС: 25.0%	140.0	ЗӨУ: 28.0%, ЗӨС: 28.0%	150.0	ЗӨУ: 30.0%, ЗӨС: 30.0%	160.0	ЭМЯ, ХӨСҮТ	Холбогдох төрийн байгууллагууд
2.6	Эрсдэлт бүлгийн хүн амын БЗДХ, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний сайжруулах	Глобаль сан	256.0	Жил бүр	Жилд 1 удаа	64.0	Жилд 1 удаа	64.0	Жилд 1 удаа	64.0	Жилд 1 удаа	64.0	ХӨСҮТ, ЦЕГ, ШШГЕГ	Аймаг, нийслэлийн ЭМГ, ЭМТ, ӨЭМГ, ЗОХИШ Холбогдох төрийн болон ТББ-ууд
2.7	Нийт хүн амын дунд БЗДХ, ХДХВ-ийн халдварын идэвхтэй талалт, эрт илрүүлгийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх	Глобаль сан	120.0	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн тэмдүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд 34,111 хүн хамрагдсан.	10,000 хүн	30	10,000 хүн	30.0	10,000 хүн	30.0	10,000 хүн	30.0	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, дүүргийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, БОЗТ
2.8	Төрөлхийн тэмдүүгийн тохиолдол хяналтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах	Улсын төсөв	40.0	100,000 амьд төрөлтөд тохиолдлын түвшин 2022 онд 30.5 байсан	100,000 амьд төрөлтөд тохиолдлын түвшинг 20-иос доош байлгана	10	100,000 амьд төрөлтөд тохиолдлын түвшинг 18-аас доош байлгана	10.0	100,000 амьд төрөлтөд тохиолдлын түвшинг 15-аас доош байлгана	10.0	100,000 амьд төрөлтөд тохиолдлын түвшинг 15-аас доош байлгана	10.0	ХӨСҮТ АНЭМГ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд
2.9	ХДХВ-ийн халдвараас сэргийлэх ӨӨС-ийг өргөжүүлэх	Глобаль сан	220.0	-	50 хүнийг ӨӨС-д хамруулсан байна	55	100 хүнийг ӨӨС-д хамруулсан байна	55.0	100 хүнийг ӨӨС-д хамруулсан байна	55.0	100 хүнийг ӨӨС-д хамруулсан байна	55.0	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймгийн НЗ, дүүргийн ЭМГ-үүд

2.10	Эхээс хүхүдэд ХДХВ, гепатит В вирус, тэмбүүгийн халдвар дамжихаас сэргийлэх сургалт зохион байгуулах	Глобаль сан	145.0	2025 онд 2 аймаг	Баруун бүсийн 4 аймагт сургалт зохион байгуулсан байна	зүүн бүсийн 4 аймагт сургалт зохион байгуулсан байна	35.0	Хангайн бүсийн 4 аймагт сургалт зохион байгуулсан байна	40.0	Төвийн бүсийн 4 аймаг, Улаанбаатарын 4 дүүрэгт сургалт зохион байгуулсан байна	40.0	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, дүүргийн ЭМГ
Зорилт 3: БЗДХ, ХДХВ, ДОХ-той хүмүүсийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах													
Хэсгийн дүн			4,220				987		1,033		1,088		1,108
3.1	ХДХВ-ийн халдварын үеийн эмчилгээ, тусламж үйлчилгээнд тууштай хамрагдахыг сайжруулах	Глобаль сан	2104.0	2025 онд эмчилгээ, тусламж үйлчилгээнд 292 хүн хамрагдсан	326 хүнийг эмчилгээнд хамруулсан байна	533.0	360 хүнийг эмчилгээнд хамруулсан байна	519.0	384 хүнийг эмчилгээнд хамруулсан байна	404 хүнийг эмчилгээнд хамруулсан байна	533.0	ЭМЯ, ХӨСҮТ	Холбогдох төрийн болон ТББ-ууд
3.2	ХДХВ-ийн халдварын үеийн эмчилгээ, тусламж үйлчилгээний үр дүн, үр шийг тусламж, хамрагдахыг сайжруулах	Глобаль сан	1408.0	2024 онд эмчилгээнд хамрагдсан хүмүүсийн 84%-ийг нь вирусийн ачаалал дарангуйлагдсан байна	Эмчилгээнд хамрагдсан хүмүүсийн 95%-ийнх нь вирусийн ачаалал дарангуйлагдсан байна	169.0	Эмчилгээнд хамрагдсан хүмүүсийн 95%-ийнх нь вирусийн ачаалал дарангуйлагдсан байна	519.0	Эмчилгээнд хамрагдсан хүмүүсийн 95%-ийнх нь вирусийн ачаалал дарангуйлагдсан байна	Эмчилгээнд хамрагдсан хүмүүсийн 95%-ийнх нь вирусийн ачаалал дарангуйлагдсан байна	533.0	ЭМЯ, ХӨСҮТ	Холбогдох байгууллагууд
3.3	Сүрьеэ, ХДХВ-ийн хаавсарсан халдварын илрүүлэлт, эмчилгээ тусламж үйлчилгээг сайжруулах	Глобаль сан	168.0	2025 онд сүрьеэтэй оношлогдсон хүмүүсийн 85.6%-ийг нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулсан	Шинээр сүрьеэтэй оношлогдсон хүмүүсийн 90%-ийг ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулсан байна	42.0	Шинээр сүрьеэтэй оношлогдсон хүмүүсийн 90%-ийг ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулсан байна	42.0	Шинээр сүрьеэтэй оношлогдсон хүмүүсийн 94%-ийг ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулсан байна	Шинээр сүрьеэтэй оношлогдсон хүмүүсийн 94%-ийг ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулсан байна	42.0	ЭМЯ, ХӨСҮТ	Холбогдох төрийн болон ТББ-ууд
3.4	БЗДХ, ХДХВ/ДОХ-той хүмүүст үзүүлж буй тусламж үйлчилгээнд сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлэх	Глобаль сан	827.0	-	Улиралд 100 хүнийг сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулсан байна	196.0	Улиралд 100 хүнийг сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулсан байна	239.0	Улиралд 100 хүнийг сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулсан байна	Улиралд 100 хүнийг сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамруулсан байна	196.0	ХӨСҮТ СЭМҮТ	Аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар, ТББ
3.5	Хүний эрхийн зөрчлийг арилгах замаар тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах "Бид нэг тэнгэртэй" үйл ажиллагааг зохион байгуулах	Глобаль сан	236.0	Үе шаттай зохион байгуулах шаардлагатай	жигд 2 удаа зохион байгуулсан байна	44.0	жигд 2 удаа зохион байгуулсан байна	64.0	жигд 2 удаа зохион байгуулсан байна	жигд 2 удаа зохион байгуулсан байна	64.0	ХӨСҮТ	Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд
3.6	Тусламж, үйлчилгээ үзүүлэгчдэд болон эрсдэлт бүлгийн хүн амд хүний эрх, жэндэрийн мэдлэг олгох	Глобаль сан	186.0	-	Гарын авлага боловсруулсан байна	46.0	4 удаагийн сургалтаар 120 хүнийг сургалсан байна	46.0	4 удаагийн сургалтаар 120 хүнийг сургалсан байна	4 удаагийн сургалтаар 120 хүнийг сургалсан байна	46.0	ЭМЯ, ХӨСҮТ	Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд
3.7	Монгол Улсад ДОХ, Сүрьеэгийн хөтөлбөрийн олон улсын хараат бус хөндлөнгийн үнэлгээг зохион байгуулах, зөвлөмжийг хэрэгжүүлэх	Глобаль сан	285.0	Хөндлөнгийн үнэлгээ 2022 онд хийгдсэн	Үнэлгээ хийгдсэн байна	285.0	Зөвлөмжийг төлөвлөгөөнд тусган өөрчлөлт оруулах	-	Зөвлөмжийн 50% хэрэгжсэн байна	Зөвлөмж >90% хэрэгжсэн байна	-	ХӨСҮТ	Холбогдох төрийн болон ТББ-ууд
Хэсгийн дүн			5,262			1,325		1,064		1,449		1,424	
Зорилт 4: БЗДХ, ХДХВ, ДОХ-ын нөлөөгөөнд суурилсан хяналт, тандалт, мэдээллийн системийг боловсронгуй болгох													
4.1	БЗДХ, ХДХВ-ийн халдварын хавьталчид үзүүлэх тусламж үйлчилгээний хамрагдахыг нэмэгдүүлэх	Глобаль сан	372.0	Хавьтал судлалын индекс 0.5	0.5	93.0	0.6	93.0	0.7	93.0	0.8	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймгийн нэг дүүргийн ЭМГ-үүд

4.2	ХДХВ-ийн халдварын тохиолдлын тооцоолол хийх	Глобаль сан	32,0	687	тооцоолол хийгдсэн байна	32,0	Жилд 1 удаагийн үнэлгээг хийсэн байна	10,0	Жилд 1 удаагийн үнэлгээг хийсэн байна	ХӨСҮТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Эрүүл мэндийн яам
4.3	Дэлхийн ДОХ-ын хяналт, үнэлгээний тайлан хийх, илгээх	Глобаль сан	40,0	Жилд 1 удаа	Жилд 1 удаагийн үнэлгээг хийсэн байна	10,0	Жилд 1 удаагийн үнэлгээг хийсэн байна	10,0	Жилд 1 удаагийн үнэлгээг хийсэн байна	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймгийн НЗ, дүүргийн ЭМТ-үүд
4.4	Эрсдэлт бүлгийн хүн амын дундах ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтыг тодорхойлох	Глобаль сан	450,0	2025 онд 363, 36У, ТЖЭ-ийн дундах тархалтыг тодорхойлсон	-	363, 36У, ТЖЭ-ийн дундах ХДХВ, тэмбүүгийн тархалт, эрсдэлт зан үйлийг тодорхойлсон байна	150,0	363, 36У, ТЖЭ-ийн дундах ХДХВ, тэмбүүгийн тархалт, эрсдэлт зан үйлийг тодорхойлсон байна	150,0	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймгийн НЗ, дүүргийн ЭМТ-үүд
4.5	ХДХВ-ийн эмэнд тэсвэржилт тодорхойлох	Глобаль сан	1155,0	-	12 хүний эмийн тэсвэржилтийг тодорхойлсон байна	193,0	15 хүний эмийн тэсвэржилтийг тодорхойлсон байна	241,0	20 хүний эмийн тэсвэржилтийг тодорхойлсон байна	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймгийн НЗ, дүүргийн ЭМТ-үүд
4.6	БЗДХ-аас сэргийлэх Докси РНЕР-ийг нэвтрүүлэх	Глобаль сан	65,0	-	-	-	БЗДХ-аас сэргийлэх Докси РНЕР-ийг нэвтрүүлсэн байна	65,0	Микоплазмын үүсгэгчийн эмэнд тэсвэржилтийг тодорхойлсон байна	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймгийн НЗ, дүүргийн ЭМТ-үүд
4.7	Микоплазмын үүсгэгчийн эмэнд тэсвэржилтийн судалгаа хийх	Глобаль сан	65,0	-	-	-	-	-	Микоплазмын үүсгэгчийн эмэнд тэсвэржилтийг тодорхойлсон байна	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймгийн НЗ, дүүргийн ЭМТ-үүд
4.8	Заг хүйтний эмийн тэсвэржилтийн судалгаа хийх	Глобаль сан	130,0	-	-	-	Заг хүйтний эмийн тэсвэржилтийг тодорхойлсон байна	65,0	Заг хүйтний эмийн тэсвэржилтийг тодорхойлсон байна	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймгийн НЗ, дүүргийн ЭМТ-үүд
4.9	Тэмбүү өвчний эмчилгээний зохиистой тунгийн судалгаа хийх	Глобаль сан	114,0	-	-	-	Тэмбүү өвчний эмчилгээний зохиистой тунг тодорхойлсон байна	38,0	Тэмбүү өвчний эмчилгээний зохиистой тунг тодорхойлсон байна	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймгийн НЗ, дүүргийн ЭМТ-үүд
4.10	Заг хүйтний эмийн тэсвэржилтийн тандалтыг нэвтрүүлэх	Глобаль сан	130,0	-	-	-	-	-	Заг хүйтний эмийн тэсвэржилтийн тандалтыг нэвтрүүлсэн байна	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймгийн НЗ, дүүргийн ЭМТ-үүд
4.11	Аймаг, дүүргийн ДОХ/БЗДХ-ын кабинетын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх	Глобаль сан	140,0	4 аймаг, 9 дүүрэг	4 аймаг, 9 дүүрэгт дэмжлэгт хяналт хийсэн байна	20,0	6 аймаг, 9 дүүрэгт дэмжлэгт хяналт хийсэн байна	30,0	8 аймаг, 9 дүүрэгт дэмжлэгт хяналт хийсэн байна	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймгийн НЗ, дүүргийн ЭМТ-үүд
4.12	БЗДХ, ХДХВ/ДОХ-ын бүртгэл мэдээллийн хяналтын тогтолцоог сайжруулах	Глобаль сан	52,0	Цаасан бүртгэл мэдээлэлтэй	Халттай цахим системд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна	13,0	Халттай цахим системийг бүрэн нэвтрүүлсэн байна	13,0	Халттай цахим системд үйл ажиллагаа тогтмолжсон байна	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, аймгийн НЗ, дүүргийн ЭМТ-үүд
4.13	БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тандалтын тоо мэдээнд дүн шинжилгээ хийх	Глобаль сан	60,0	Жилд 1 удаа хийдэг	Жилд 2 удаа хийсэн байна	13,0	Жилд 2 удаа хийсэн байна	17,0	Жилд 2 удаа хийсэн байна	ЭМЯ, ХӨСҮТ	ЭМХТ, НЭМГ, Холбогдох төрийн болон ТББ-үүд

4.14	ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, тусламж үйлчилгээний үндэсний хариу арга хэмжээний санхүүгийн зарцуулалтын үнэлгээ хийх	Глобаль сан	45,0	2017-2021 оны үнэлгээ хийсэн	-	2022-2025 оны үнэлгээ хийгдсэн байна	15,0	-	2026-2028 оны үнэлгээ хийгдсэн байна	30,0	ЭМЯ, ХӨСҮТ	Аймаг, нийслэлийн ЗМГ, аймагын НЗ, дүүргийн ЗМТ-үүд, холбогдох ТББ-үүд
	Хэргийн дүн		2,904		374		769			963		
	Нийт төсөв		25,223		5,433		5,915		840	7,148		

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Эрүүл мэндийн сайдын 2026 оны
05 сарын 28 өдрийн 1189 дүгээр
тушаалын хоёрдугаар хавсралт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Сурь				Зорилтот түвшин			
			Түвшин	Он	2026 он	2027 он	2028 он	2029 он		
Зорилго: Монгол Улсын Засгийн газар 95-95-95 зорилт, 2030 онд ДОХ-ыг зогсоох;										
1.	Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн дундаж ХДХВ-ийн халдварын тархалт	Хувь	6.10	2025	≤6.1%	≤6.5%	≤6.5%	≤6.5%	≤6.5%	≤6.5%
2.	Эмэгтэй биеэ үнэлэгчдийн дундаж ХДХВ-ийн халдварын тархалт	Хувь	0	2025	0	0	0	0	0	0
3.	Трансжэндэр хүмүүсийн дундаж ХДХВ-ийн халдварын тархалт	Хувь	4.8	2025	5.7	≤5.7	≤5.7	≤5.7	≤5.7	≤5.7
4.	Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн дундаж тэмбүүгийн халдварын тархалт	Хувь	12.6	2025	13.0	13.0	13.0	13.0	13.0	13.0
5.	Эмэгтэй биеэ үнэлэгчдийн дундаж тэмбүүгийн халдварын тархалт	Хувь	5.5	2025	5.5	5.5	5.5	5.5	5.5	5.5
6.	Трансжэндэр хүмүүсийн дундаж тэмбүүгийн халдварын тархалт	Хувь	17.5	2025	17.5	18.0	18.0	18.0	18.0	18.0
7.	Жирэмсний хяналтад буй эмэгтэйчүүдийн дундаж тэмбүүгийн халдварын тархалт	Хувь	1.3	2025	≤1.0	≤1.0	≤1.0	≤1.0	≤1.0	≤1.0
8.	15-24 насны залуучуудын дундаж тэмбүүгийн тохиолдлын түвшин	10,000 хүн амд	34.5	2024	30.0	30.0	25.0	25.0	25.0	25.0
9.	15-34 насны залуучуудын дундаж зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлын түвшин	10,000 хүн амд	81.7	2024	80.0	80.0	75.0	75.0	75.0	75.0
10.	100,000 амьд төрөлтөд төрөлхийн тэмбүүтэй төрсөн нярай	100,000 хүн амд	46.2	2025	40.0	35.0	30.0	25.0	25.0	25.0
11.	ХДХВ-ийн халдвар БЗДХ-аас сэргийлэх аргыг зөв тодорхойлж, ХДХВ-ийн халдварын талаарх түгээмэл ташаа ойлголтыг үгүйсгэж чадсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд	Хувь	53.7	2025	≤55.0	≤56.0	≤57.0	≤58.0	≤58.0	≤58.0
12.	ХДХВ-ийн халдвар БЗДХ-аас сэргийлэх аргыг зөв тодорхойлж, ХДХВ-ийн халдварын талаарх түгээмэл ташаа ойлголтыг үгүйсгэж чадсан эмэгтэй биеэ үнэлэгчид	Хувь	47.2	2025	≤50.0	≤51.0	≤52.0	≤53.0	≤53.0	≤53.0
13.	ХДХВ-ийн халдвар БЗДХ-аас сэргийлэх аргыг зөв тодорхойлж, ХДХВ-ийн халдварын талаарх түгээмэл ташаа ойлголтыг үгүйсгэж чадсан трансжэндэр хүмүүс	Хувь	50.8	2025	≤51.0	≤52.0	≤53.0	≤54.0	≤54.0	≤54.0
14.	Шинээр оношлогдсон сүрьеэтэй өвчтөнүүдийн дундаж ХДХВ-	Хувь	85.6	2025	>90.0%	>90.0	>90.0	>90.0	>90.0	>90.0%

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь		Зорилготой түвшин			
			Түвшин	Он	2026 он	2027 он	2028 он	2029 он
	ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэсэн өвчтөнүүд							
15.	Хамгийн сүүлд эрэгтэй хүнтэй шулуун гэдсээр бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд	Хувь	76.8	2025	80.0	81.0	82.0	83.0
16.	Хамгийн сүүлийн үйлчлүүлэгчтэйгээ бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн эмэгтэй биеэ үнэлэгчид	Хувь	80.8	2025	81.0	82.0	83.0	84.0
17.	Хамгийн сүүлийн бэлгийн хавьтал эсвэл шулуун гэдсээр бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн трансжэндэр хүмүүс	Хувь	82.3	2025	83.0	84.0	85.0	86.0
18.	ХДХВ-ийн хөтөлбөрт хамрагдсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд - тусламж үйлчилгээний багц	Хувь	83.5	2025	85.0	87.0	89.0	90.0
19.	ХДХВ-ийн хөтөлбөрт хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчид - тусламж үйлчилгээний багц	Хувь	74.6	2025	75.0	76.0	77.0	78.0
20.	ХДХВ-ийн хөтөлбөрт хамрагдсан трансжэндэр хүмүүс - тусламж үйлчилгээний багц	Хувь	80.2	2025	82.0	84.0	86.0	88.0
21.	Сүүлийн 6 сарын хугацаанд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд	Хувь	58.1	2025	60.0	62.0	64.0	66.0
22.	Сүүлийн 6 сарын хугацаанд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчид	Хувь	40.5	2025	45.0	47.0	49.0	50.0
23.	Сүүлийн 6 сарын хугацаанд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан трансжэндэр хүмүүс	Хувь	78.7	2025	80.0	82.0	84.0	86.0
24.	Жирэмсэн эмэгтэйчүүдийн тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдалт	Хувь	98.1	2025	≤98.1	≤98.1	≤98.1	≤98.1
25.	ХДХВ-ийн халдвартай гэдгээ мэдэж байгаа ХДХВ-ийн халдвартай амьдарч байгаа хүмүүс	Хувь	51.0	2025	55.0	60.0	65.0	70.0
26.	ХДХВ-ийн халдвартай эхээс төрсөн бөгөөд төрснөөс хойш эхний хоёр сарын дотор ХДХВ илрүүлэх шинжилгээ хийлгэсэн хүүхэд	Хувь	100	2024	100	100	100	100
27.	ХДХВ-ийн халдвартай амьдарч буй хүмүүсийн дунд ретровирусийн эсрэг эмчилгээтэй хүмүүс	Хувь	42.1	2025	45	47	49	51
28.	Ретровирусийн эсрэг эмчилгээтэй хүмүүсийн дунд ХДХВ-ийн ачаалал дарангуйлагдсан хүмүүс	Хувь	95	2025	>95	>95	>95	>95
29.	Үйлчилгээний чанар сайн байсан гэж үнэлсэн ХДХВ-ийн халдварын тусламж үйлчилгээ	Хувь	68	2024	70	72	74	76
30.	Улсын төсөв болон олон улсын байгууллагаас ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, эмчилгээ, тусламж, үйлчилгээ болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан зардал	Төгрөг	7'05'122'429	2021	9.5 тэрбум	10.0 тэрбум	11.5 тэрбум	13.0 тэрбум